

САНХҮҮГИЙН ХЯНАЛТ, ДОТООД АУДИТЫН АЛБАНЫ
АРВАНХОЁР ДУГААР САРД ХИЙСЭН АЖЛЫН ТОВЧ ТАЙЛАН

2024-12-31

Баруун-Урт

Хяналт шалгалтын мэдээлэл:

Санхүүгийн хяналт, аудитын албаны 2024 онд дэвшүүлсэн зорилт, хийж гүйцэтгэх ажлын төлөвлөгөөний дагуу Монгол Улсын Төсвийн тухай, Төрийн хяналт шалгалтын тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай, Шилэн дансны тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомж түүнийг үндэслэн Төрийн эрх бүхий байгууллагаас нийтээр дагаж мөрдөхөөр тогтоосон дүрэм, журам, стандартын биелэлт, хэрэгжилтэнд хяналт тавьж, тухайн байгууллагын өмч хөрөнгийн ашиглалт, зарцуулалтад дүгнэлт өгөх илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулах, мэргэжлийн заавар зөвлөмж өгч ажиллалаа.

Албаны даргын баталсан 2024 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн 07 тоот дотоод аудитын удирдамжийн дагуу төсвийн Ерөнхийлөн захирагчийн харьяаны төсвийн багцад харьяалагдах байгууллагуудын 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 12 дугаар сарын 20-ны өдөр хүртэлх шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд дотоод аудитын шалгалт хийгдэж байна.

Бусад мэдээлэл:

Тус алба нь 2024 оны Санхүүчдийн баярын үйл ажиллагааг зохион байгуулсан.

ТАЙЛАН БИЧСЭН:

ДОТООД АУДИТОР

Б.УЯНГАНЯМ